



ДУНДГОВЬ АЙМАГ ГОВЬ-УГТААЛ СҮМ

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2014 ОН



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭӨГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 01

Хажуу шинэ ус

Г Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөл
байгуулах тухай

Монгол улсын Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 2,
Амьжиргааг дэмжих зөвлөлийн дүрмийн 1-ийн 2 дахь заалтыг тус тус үндэслэн
сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ :

1. Сумын амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг
дараахь бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

Зөвлөлийн дарга Г. Эрдэнэцэцэг /Тамгын газрын дарга /

Нарийн бичгийн дарга: Б. Булгамаа /Нийгмийн ажилтан /

Гишүүд: Д. Жаргалмаа /ИТХ-ын нарийн бичгийн дарга /

Б. Бархасмаа /ТББ-ын төлөөлөл /

Т. Жагай /ТББ-ын төлөөлөл /

Б. Батжаргал /Иргэдийн төлөөлөл /

Д. Чанцалдулам /Нийгмийн бодлогын ажилтан /

2. Нийгмийн халамжийн тухай хуулийн холбогдох заалтуудын хэрэгжилтийг
хангаж нийгмийн халамжийн үйлчилгээ шаардлагатай иргэдийг бүрэн хамруулж
ажиллахыг зөвлөлийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3. Зөвлөлийн гүйцэтгэсэн ажил, үр дүнгийн талаар хагас бүтэн жилээр ИТХ-ын
Тэргүүлэгчдийн хуралд тайлагнаж байхыг зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.
Булгамаад даалгасугай.

4. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012 оны 08 дугаар тогтоолыг хүчингүй
болсонд тооцсугай.

ДАРГА 
V. НЯМСҮРЭН



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 03


Хажуу шинэ ус

Тэргүүлэгчдийн ажлыг дүгнэх
журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1-ийн 3-ыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ :

1.Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлыг дүгнэх журмыг хавсралтаар баталсугай.

2.Тухайн журмын дагуу Тэргүүлэгчдийн ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэж, үнэлгээний дүнгийн талаар Тэргүүлэгчдийн хуралд мэдээлж байхыг ИТХ-ын дарга В. Нямсүрэнд даалгасугай.

ДАРГА  В. НЯМСҮРЭН

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 01 сарын
20... өдрийн 03 тоот тогтоолын хавсралт

СУМЫН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН АЖЛЫГ
ДҮГНЭХ ЖУРАМ

Нэг.Зорилго: Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийг хурлын байгууллагын үйл ажиллагаанд тогтмол оролцуулах, Хурал иргэдийн хоорондын холбоог ойртуулах, ажлын арга барил, үйл ажиллагааны ололт амжилт, дутагдалтай байдлыг жишиж зэрэгцүүлж үнэлэх, улмаар ажил сайжруулах, харилцан туршлагыг солилцуулах, үйл ажиллагааг хууль эрх зүйн хүрээнд төлөвшихөд туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Дүгнэх үзүүлэлт:

1. Сумын ИТХ-ын хуралдаан, Тэргүүлэгчдийн хурал, хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх болон хяналт шалгалтын ажилд оролцсон байдал
2. Хууль тогтоомж, хурлын шийдвэрийг иргэдэд тайлбарлан таниулсан байдал \материалжуулах\
3. Хууль тогтоомж, хурлын шийдвэрийн биелэлтийг хангуулах, орон нутгийн эдийн засаг, нийгмийн шаардлагатай асуудлаар холбогдох албан тушаалтанд асуулга тавьж хяналт шалгалт явуулсан байдал
4. Хурлын ажлын хороо, тэргүүлэгчдийн хуралд эдийн засаг нийгмийн тулгамдсан асуудлаар санал оруулж хэлэлцүүлсэн байдал
5. Иргэдтэй тогтмол холбоотой ажиллаж, тэднээс тавьсан өргөдөл, санал гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэсэн байдал

Гурав. Дүгнэх журам

Үзүүлэлт бүрд 1-5 оноо өгч , үнэлгээний дүнг үзүүлэлт бүрээр нэг бүрчлэн дэлгэрэнгүй Тэргүүлэгч тус бүр дээр танилцуулна. /Үзүүлэлтийг үзэмжээр эсвэл ам яриагаар биш хийсэн бодит ажил үйлчилгээ үр дүнгээр тооцоход чиглүүлж нэгэн адил аргачлалаар дүгнэх/

Журмыг хагас, бүтэн жилээр сумын ИТХ-ын дарга дүгнэж жилийн эцэст хамгийн өндөр оноо авсан нэг Тэргүүлэгчийг сумын ИТХ-ын өргөмжлөл, 30000 төгрөгөөр шагнаж урамшуулна.



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 04

Хажуу шинэ ус

Г Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны
ажлын төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3, 22.1.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс 2014 онд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. 2014 оны төлөвлөгөөг бүтээлчээр хэрэгжүүлж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас жилээр тооцож Тэргүүлэгчдийн хуралд мэдээлж байхыг нарийн бичгийн дарга Д. Жаргалмаад үүрэг болгосугай.



ДАРГА

В. НЯМСҮРЭН



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 01 сарын 20 одор

Дугаар 04

Хажуу шинэ ус

Г Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны
ажлын төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3, 22.1.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс 2014 онд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. 2014 оны төлөвлөгөөг бүтээлчээр хэрэгжүүлж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас жилээр тооцож Тэргүүлэгчдийн хуралд мэдээлж байхыг нарийн бичгийн дарга Д. Жаргалмаад үүрэг болгосугай.

ДАРГА
В. НЯМСҮРЭН

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 01.
сарын 20... өдрийн 07 тоот тогтоолын хавсралт

ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДЭЭС 2014 ОНД
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийгдэх ажлын агуулга	Хугацаа	Хариуцах эзэн
Нэг. Зохион байгуулалтын ажлын талаар			
1	2014 оны ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулан Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах	1 сарын 20-ны дотор	Д. Жаргалмаа
2	Иргэдээс авсан саналыг багцлан ИТХ-ын ажлын төлөвлөгөө, иргэний танхимаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тусгах	1-р сард	Д.Жаргалмаа
3	Сумын ИТХ-ын хуралдааныг 2 –оос доoshgүй удаа хуралдуулах	Жилдээ	В. Нямсүрэн Тэргүүлэгчид
4	Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлыг сард 2-оос доoshgүй удаа хуралдуулах	Сар бүр	В. Нямсүрэн
5	Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлыг дүгнэх журмыг боловсруулан батлуулж, Тэргүүлэгчдийн ажлыг хагас бүтэн жилээр дүгнэж ажиллах	6,12-р сард	В. Нямсүрэн
6	Хурлын хороодын ажлыг дүгнэх журмыг боловсруулан Тэргүүлэгчдийн хуралд оруулж батлуулан мөрдөж ажиллах	2-р сард	Д. Жаргалмаа Хороодын дарга нар
7	Багийн ИНХ-ын дарга нарын ажлыг дүгнэх журмыг боловсруулан батлуулах, сар бүр ажлын тайланг авч урамшууллыг олгодог байх	Сар бүр	Д. Жаргалмаа Багийн ИНХ-ын дарга нар
8	ЗГ-ын болон аймаг, сумын ИТХ, Тэргүүлэгчдийн тогтоол шийдвэрийг бүртгэл хяналтанд авч хэрэгжилтийг тооцож мэдээлж ажиллах	Хагас, бүтэн жилээр	Д. Жаргалмаа, Иргэний танхимиын ажилтан
9	Төлөөлөгчийн өдрийг жилд 1 удаа тусгай удирдамж хөтөлбөрийн дагуу зохион байгуулах	Жилдээ	В. Нямсүрэн, Тэргүүлэгчид
10	Төлөөлөгч нарын ажлыг дүгнэх журмыг боловсруулан ИТХ-д танилцуулах	2-р улиралд	Д. Жаргалмаа
11	Иргэний танхимаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө боловсруулан батлуулж ажиллах	2-р сард	Иргэний танхимиын ажилтан
12	Хяналт шинжилгээ үнэлгээний багаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллах	2-р сараас	Д. Жаргалмаа
Хоёр. Сургалт сурталчилгааны талаар			
13	Багийн ИНХ-ын дарга нарыг сургалтанд хамруулах	2-р сард	Д. Жаргалмаа
14	Хурлын төлөөлөгч наарт хууль эрх зүйн сургалтыг аймгийн ИТХ-тай хамтран зохион байгуулах	Жилдээ	В. Нямсүрэн Д. Жаргалмаа

15	Тэргүүлэгч, багийн ИНХ-ын дарга нарт хууль эрх зүйн болон бусад сургалтыг зохион байгуулах	Улирал тутам	В. Нямсүрэн Д. Жаргалмаа, Тэргүүлэгчид
16	Иргэний танхимаар сумын ИТХ, тэргүүлэгчдээс гаргасан тогтоол шийдвэрийг иргэдэд таниулах сурталчилах ажлыг зохион байгуулах	Жилдээ	Д. Жаргалмаа Иргэний танхимын ажилтан
17	Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах суурин утас, цахим хаягийг тогтмол ажиллуулах	Жилдээ	Иргэний танхимын ажилтан
18	Сумын ИТХ-ын веб хаяг нээж мэдээ мэдээллийг байнга шинэчлэн тавьж байх	Жилдээ	Д. Жаргалмаа, иргэний танхимын ажилтан
19	Сумын ИТХ, Тэргүүлэгчдийн хуралд иргэдийг оролцуулж хурлын нээлттэй байдлыг хангаж ажиллах	Жилдээ	В. Нямсүрэн, Д. Жаргалмаа, Тэргүүлэгчид
20	Багийн ИНХ-ын үйл ажиллагаанд оролцож мэдээлэл өгөх, тэдний санал хүсэлтийг сонсож шийдвэрлэх	Улирал тутам	В. Нямсүрэн, Д. Жаргалмаа Тэргүүлэгчид
21	“Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь” сургалтыг иргэдэд зохион байгуулах	2-р улиралд	Д. Жаргалмаа Мэргэжлийн байгууллагатай хамtran

Гурав. Хяналт шалгалтын талаар

22	Тухайн жилд явуулах хяналт шалгалтын графикийг батлан Тэргүүлэгч, хурлын хороодод хариуцуулан ажиллах	2-р сард	В. Нямсүрэн
23	Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих	Хагас, бүтэн жилээр	Төсөв, санхүү эдийн засгийн хороо
24	Төсвийн зардлын зарцуулалтын байдалд хяналт тавих	Хагас, бүтэн жилээр	
25	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр орон нутагт хийгдэх бүтээн байгуулалтын ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавих	Жилдээ	Тэргүүлэгчид
26	Ашиглалтын болон хайгуулын лицензтэй ААН-үүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах	Улирал тутам	Тэргүүлэгчид, хороод
27	Ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн тайланг иргэдэд тавиулах ажлыг зохион байгуулах	Жилд 2 удаа	Төрийн бодлого, хууль зүй хяналтын хороо
28	Хүнсний аюулгүй байдалд хяналт тавьж ажиллах	Улирал тутам	Нийгмийн бодлого, үйлдвэрлэл ХАА-н хороо
29	Соёлын төвийн үйл ажиллагаа, үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд хяналт тавих	1-р улиралд	НБ, үйлдвэрлэл, ХАА-н хороо
30	Орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан газар нутгийг байгаль орчин, кадастрын албандаа бүртгүүлсэн байдалд хяналт тавих	1-р улиралд	Дэд бүтэц, ГЗБ, байгаль экологийн хороо

Дөрөв. Хурлын хороод, багийн ИНХ-тай ажиллах талаар

31	Багийн сан бүрдүүлэх, зарцуулах журмыг багийн ИНХ-аар хэлэлцүүлэн батлуулах	1,2-р улиралд	Багийн ИНХ-ын дарга нар
----	---	---------------	-------------------------

32	Багийн ИНХ-ын дарга нарыг дэвтрээр хангах, дэвтэр хөтлөлтийн байдалд хяналт тавьж зөвлөгөө өгч ажиллах	Жилдээ	Д.Жаргалмаа
33	Багийн ИНХ-ын хуралдааны материалыг цэгцлэн архивын нэгж үүсгэн хадгалах талаар сургалт зохион байгуулах	3-р сард	Д. Жаргалмаа
34	Хурлын хороодын үйл ажиллагааг идэвхижүүлж тогтмол ажиллуулах	Жилдээ	В. Нямсүрэн

Тав. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар

35	ГХУССЗ-ийн 2014 оны ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр Тэргүүлэгчдийн хуралд оруулж мэдээлэх	Хагас, бүтэн жилээр	В. Нямсүрэн Мягмарсүрэн
36	ГХУС талаар зохион байгуулсан ажлын мэдээг сар тутам Тэргүүлэгчдэд мэдээлж байх	Сар тутам	Цагдаагийн хэсэг
37	Архидан согтуурснаас хүний эрүүл мэнд, гэр бүл, нийгмийн амьдралд учрах хор уршгийн талаар болон уламжлалт ёс заншил, хууль эрх зүйн мэдээлэл сургалт сурталчилгааг зохион байгуулах	Жилдээ	ГХУССЗ
38	Архичид цугларч архиддаг айл өрхүүдийг хяналтандaa авч тэдэнд зөвлөгөө өгөх, гэр орондоо удаа дараа архидуулдаг хүмүүстэй уулзаж анхааруулга өгөх	Жилдээ	Цагдаагийн хэсэг, БЗД нар
39	Архины хэрэглээг багасгах талаар соён гэгээрүүлэх сургалт сурталчилгааг тусгай удирдамж хөтөлбөрийн дагуу үе шаттай зохион байгуулах	Жилдээ	ГХУССЗ

Зургаа. Бусад ажлын талаар

40	Үндсэн хууль баталсан өдрийг орон нутагтаяа тэмдэглэх	1-р сарын 13	В. Нямсүрэн Д.Жаргалмаа
41	ҮЗ-н үйл ажиллагааны талаар иргэдэд мэдээлэл өгөх, татварыг бүрэн төвлөрүүлэхэд анхаарах	Жилдээ	В. Нямсүрэн
42	Донорын өдрийн хүрээнд доноруудад хүндэтгэл үзүүлэх, хүндэт доноорт тодорхойлох	5-р сард	В. Нямсүрэн Д. Жаргалмаа
43	Хэлмэгдэгсийн дурсгалыг хүндэтгэх, үр хүүхдүүдийг хүлээн авч уулзах	9 сарын 10	В. Нямсүрэн Д. Жаргалмаа

Төлөвлөгөө гаргасан:
ИТХ-ын нарийн бичгийн дарга  Д. Жаргалмаа



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 02 сарын 12-дээр

Дугаар 08

Хажуу шинэ ус

Г Хурлын хороодын ажлыг дүгнэх
журам батлах тухай Г

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.11, 21 дүгээр зүйлийн 21.3 дахь заалт, Сумын ИТХ-ын 2012 оны анхдугаар хуралдаанаар баталсан хороодын үйл ажиллагааны журмын 1.8 дахь заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ :

- Сумын ИТХ-ын хороодын ажлыг дүгнэх журмыг хавсралтаар баталсугай.
- Тухайн журмын дагуу ажлаа хагас бүтэн жилээр тайлагнаж байхыг хороодын дарга нарт, хороодын ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэж байхыг ИТХ-ын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

ДАРГА  В. НЯМСҮРЭН

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны ~~10~~ сарын
~~28.~~ өдрийн ~~08.~~ тоот тогтоолын хавсралт

СУМЫН ИТХ-ЫН ХОРООДЫН АЖЛЫГ
ДҮГНЭХ ЖУРАМ

Нэг.Зорилго: Сумын ИТХ-ын тасралтгүй байнгын үйл ажиллагааг хангах, ажлыг тогтмолжуулах, нутгийн өөрөө удирдах ёсыг төлөвшүүлэх, иргэд, олон нийтийн санал бодлыг судлах, ажлын арга барил, үйл ажиллагааны ололт амжилт, дутагдалтай байдлыг засаж сайжруулах, үйл ажиллагааг хууль эрх зүйн хүрээнд төлөвшихөд туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Дүгнэх үзүүлэлт:

1. Хороодын ажлын төлөвлөгөө /жил, улирлын/ түүний хэрэгжилт
2. Хороодын хурлын тогтмолжилт /хурлын тэмдэглэл, материал/
3. Хороодын хийж хэрэгжүүлсэн ажил, үр дүн /ажлын удирдамж чиглэл/
4. Хороодын хурлаас гаргасан шийдвэр /Санал, дүгнэлт, зөвлөмж/
5. Сумын ИТХ, Тэргүүлэгчдийн хуралд тодорхой асуудлыг санаачлан хэлэлцүүлсэн байдал

Гурав. Дүгнэх журам

- Үзүүлэлт бүрд 5 хүртэл оноо өгөх ба хийсэн ажил, түүний үр дүнг баримт материалыг үндэслэн заавал бүхэл оноо өгөхгүй бутархай оноо ч өгч болно. Тэргүүлэгч тус бүр үзүүлэлт бүр дээр оноо өгч нийт нийлбэр оноог Тэргүүлэгчдийн тоонд хуваан дундаж оноог гаргана.
- Хороодын ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэж жилийн эцэст хамгийн өндөр оноо авсан нэг Хороог сумын ИТХ-ын өргөмжлөл, 50 000 төгрөгөөр шагнаж урамшуулна.



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 09

Хажуу шинэ ус

Г Багийн Иргэдийн Нийтийн Хурлын дарга
нарын ажлыг дүгнэх журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, 20.2, 38 дугаар зүйлийн 38.6 дахь заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ :

- 1.Багийн ИНХ-ын дарга нарын ажлыг дүгнэх журмыг хавсралтаар баталсугай.
2. Сар бүр хийсэн ажлынхаа тайланг ИТХ-ын ажлын албанд ирүүлж байхыг багийн ИНХ-ын дарга нарт үүрэг болгосугай.
- 3.Тухайн журмын дагуу багийн ИНХ-ын дарга нарын ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэж байхыг сумын ИТХ-ын ажлын албанд үүрэг болгосугай.



Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 12. сарын
28. өдрийн 07. тоот тогтоолын хавсралт

БАГИЙН ИНХ-ЫН ДАРГА НАРЫН АЖЛЫГ
ДҮГНЭХ ЖУРАМ

Нэг. Зорилго: НӨҮҮБ-ын анхан шатны нэгж болох багийн ИНХ-ын тасралтгүй байнгын үйл ажиллагааг хангах, ажлыг тогтмолжуулах, нутгийн өөрөө удирдах ёсыг төлөвшүүлэх, ажлын арга барил, үйл ажиллагааны ололт амжилт, дутагдалтай байдлыг засаж сайжруулах, үйл ажиллагааг хууль эрх зүйн хүрээнд төлөвшихөд туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Дүгнэх үзүүлэлт:

1. Багийн ИНХ-ын дэвтэр хөтлөлт
2. Багийн ИНХ-ын бичиг хэргийн стандартын мөрдөлт /ирсэн явсан бичгийн хөтлөлт/
3. Ажлын төлөвлөгөө /жил, улирлын/ түүний хэрэгжилт
4. Багийн ИНХ-ын тогтмолжилт /хурлын тэмдэглэл, хурлын материал/
5. Багийн ИНХ-аас гаргасан шийдвэр
6. Багийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, багийн сангийн журам, зарцуулалтанд хяналт тавьж ажилласан байдал
7. Иргэдийн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн байдал
8. Иргэдэд мэдлэг олгох, мэдээлэл өгөх, хууль эрх зүйн сургалт семинар, ГХУС чиглэлээр зохион байгуулсан ажил
9. Ард иргэдийн үнэлгээ

Гурав. Дүгнэх журам

- Сар бүрийн 20-ны дотор хийсэн ажлын мэдээгээ ажлын албанад ирүүлнэ.
- Үзүүлэлт бүрд 1- 5 оноо өгч, хийсэн ажил, түүний үр дүнг баримт материалыг үндэслэн дүгнэнэ.
- Багийн ИНХ-ын ажлын талаар тухайн багийн 30 иргэнээс санал асуулгын хуудсаар саналыг авч үнэлгээг гаргана.
- Багийн ИНХ-ын дарга нарын ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэж дүнг Тэргүүлэгчдийн хуралд танилцуулна.



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 19

Хажуу шинэ ус

Хуучин ЗДТГ-ын конторын байрыг
түрээслэх үнэ тарифыг
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1.2 –ийн “Г” заалт, Сумын ЗДТГ-ын даргын 2014 оны 04 сарын 30-ны өдрийн 3/134 тоот албан бичгийг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ :

- Суманд жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаа явуулахад нь дэмжлэг үзүүлж хуучин ЗДТГ-ын конторын байрыг гэрээгээр ашиглаулах үнэ тарифыг хавсралтаар баталсугай.
- Байрны сарын хураамжийн орлогыг тухай бүр дансанд төвлөрүүлж зарцуулахыг ЗДТГ-ын дарга Г. Эрдэнэцэцэг, нягтлан бодогч С. Эрдэнэмөнх нарт үүрэг болгосугай.



ДАРГА

В.НЯМСҮРЭН

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2014 оны 04 сарын 30.-ны өдрийн
13 дугаар тогтоолын хавсралт

Хуучин ЗДТГ-ын конторын байрыг түрээслэх үнэ тариф

Д/д	Түрээслэх өрөөнүүд	M ²	Сарын хураамж
1	Нийгмийн халамжийн өрөө	16.2	10000
2	Нийгмийн даатгалын өрөө	16.2	10000
3	Цагдаагийн өрөө	15.0	10000
4	Сумын засаг даргын өрөө	17.4	20000
5	Багийн Засаг дарга нарын өрөө	24.6	30000
6	Нягтлан бодогчийн өрөө	21.6	40000
7	ИТХ-ын өрөө	17.0	15000
8	ЗДТГ-ын даргын өрөө	17.4	20000

Жич: Дээрхи хураамж нь урин дулааны улирлын халаалтгүй үеийнхээр тооцсон болно.

Явуулын үйлчилгээ үзүүлэгчдэд өрөөний түрээс өдрийн 5000-8000 төгрөг



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 20

Хажуу шинэ ус

Г Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Г
ээлжит 6 дугаар хуралдааны тов,
хэлэлцэх асуудлын тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 23 дугаар зүйлийн 23.4 дэхь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ :

1.Сумын ИТХ-ын ээлжит 6 дугаар хуралдааныг 2014 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 11⁰⁰ цагт сумын төвд хуралдуулсугай.

2. Тухайн хуралдаанд доорхи үндсэн асуудлуудыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:

1.Сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, түүнд үнэлэлт дүгнэлт өгөх

2.2015 онд орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэх ажил үйлчилгээний жагсаалт, төсвийг хэлэлцэж батлах

3. 2013 оны төсвийн гүйцэтгэл, Аудитын дүгнэлт


4. 2014 оны ОНХС-ын хөрөнгийн зарцуулалт,2014 онд хийгдэх ажилд нэмэлт оруулах

5.Гэмт хэргийн гаралт, нөхцөл, цаашид авах арга хэмжээний талаар сумын хэсгийн төлөөлөгчийн сонсгал

6.Сумын 90 жилийн ойн баяр наадмын төсвийн задаргаа

7.Сумын нутаг дэвсгэрт хурдан морины уралдаан зохион байгуулахад мөрдөж ажиллах журам

3.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 6 дугаар хуралдаанаар хэлэлцэх асуудлуудыг хуралдаанд асуудал боловсруулж оруулах журмын дагуу сайтар боловсруулан хуралдаанд оруулахыг сумын Засаг дарга Б. Доржсүмбэрт, хуралдааны бэлтгэлийг сайтар хангаж ажиллахыг нарийн бичгийн дарга /Д. Жаргалмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА 
В.НЯМСҮРЭН



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУУЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 22

Хажуу шинэ ус

Г Хөрөнгийг данс хооронд шилжүүлэн
бүртгэх тухай Г

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 3 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журмын 2.3.1, Сумын 9 жилийн дунд сургуулийн 2014 оны 18 тоот албан бичгийг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ :

1. Тус сумын дунд сургуулийн бусад үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй кабинетийн 27765.309.44 төгрөгийн хөрөнгийг тухайн дансны бүртгэлээс хасалт хийж бараа материалын тусгай зориулалтын дансанд шилжүүлэн бүртгэсүгэй.
2. Шилжүүлэн бүртгэх материалын жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Өмч хөрөнгийн эзэмшил ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдалд хяналт тавьж ажиллахыг Сургуулийн захирал, нярав нарт даалгасугай.

ДАРГА  В.НЯМСҮРЭН

Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2014 оны
 06.....сарын 00.ны өдрийн 00 тоот
 ТОГТООЛЫН ХАВСРАЛТ

МАТЕРИАЛЫН ҮЛДЭГДЭЛ

Код	Нэр	Н.Б.ҮНЭ	Тоо	Дүн
00001590	6-настийн ариун цэврийн ком	11,825,000.00	1.00	11,825,000.00
00001233	6н 12 өгтэй өнгийн ксилопон	3,356.00	19.00	63,764.00
00001224	6н Raihow	6,480.00	10.00	64,800.00
00001228	6н өрдөг тоглоом	3,935.00	10.00	39,350.00
00001241	6н үсгийн сан	19,674.00	2.00	39,348.00
00001225	6н босоо сампин	16,200.00	2.00	32,400.00
00001223	6н геометрийн биет болон хавтгай дүрсүү	12,962.00	6.00	77,772.00
00001229	6н геометрийн дүрс бүхий барьж байгуулалт	9,837.00	10.00	98,370.00
00001216	6н геометрийн дүрсүүд	4,050.00	10.00	40,500.00
00001240	6н даам	3,009.00	6.00	18,054.00
00001235	6н домино	4,629.00	8.00	37,032.00
00001236	6н дээс	1,273.00	19.00	24,187.00
00001230	6н зохион бүтээх багц	10,878.00	14.00	152,292.00
00001231	6н кастнет	462.00	67.00	30,954.00
00001234	6н модон шоо	1,157.00	10.00	11,570.00
00001227	6н резинээр дүрс үүсгэдэг тоглоом	4,050.00	20.00	81,000.00
00001222	6н саваа моднууд	12,036.00	2.00	24,072.00
00001226	6н танграм	15,740.00	10.00	157,400.00
00001238	6н томрууллаг шил	22,220.00	2.00	44,440.00
00001218	6н тооны самбар	2,777.00	5.00	13,885.00
00001220	6н тоотой байшин	8,100.00	4.00	32,400.00
00001219	6н тэнцвэрийн хавтан	3,703.00	7.00	25,921.00
00001221	6н хоёр талдаа өнгөтэй тоолох дүрсүүд	1,273.00	14.00	17,822.00
00001242	6н цаг	1,877.00	2.00	3,754.00
00001217	6н шүр сүвлэх тоглоом	5,903.00	8.00	47,224.00
00001232	6н шагшуур тоглоом	462.00	70.00	32,340.00
00001239	6н шатар	4,629.00	6.00	27,774.00
00001237	6н эспандер	3,471.00	10.00	34,710.00
00001237	6н эспандер	4,166.00	10.00	41,660.00
00001339	Био Ургамал	5,730.91	2.00	11,461.82
00001314	Био Хүнсний ногoo	6,729.48	2.00	13,458.96
00001315	Био Амьтны слайд	6,885.05	2.00	13,770.10
00001330	Био Араг яс	11,481.72	2.00	22,963.44
00001328	Био Бөөр	11,481.72	2.00	22,963.44
00001324	Био Гагнуурын багаж	6,745.76	2.00	13,491.52
00001316	Био Даралтын аппарат	37,330.53	2.00	74,661.06
00001317	Био Диск / харааны хэмжигч/	56,744.77	1.00	56,744.77

00001331	Био Зүрх	11,481.72	2.00	22,963.44
00001337	Био Микроскоп	111,394.60	2.00	222,789.20
00001329	Био Нүд	11,481.72	2.00	22,963.44
00001332	Био Насанд хүрсэн эрэгтэй	11,481.72	2.00	22,963.44
00001325	Био Петрийн сав	676.57	15.00	10,148.55
00001319	Био Слайдууд	6,745.76	2.00	13,491.52
00001338	Био Стерескоп микроскоп	118,160.26	2.00	236,320.52
00001333	Био Торох насны эмэгтэй	11,481.72	2.00	22,963.44
00001336	Био Тархины бүтцийн бүдүүвч	11,481.72	2.00	22,963.44
00001318	Био Томруулагч шил 75 мм	3,382.83	20.00	67,656.60
00001320	Био Урвалын таваг	1,492.43	15.00	22,386.45
00001334	Био Уушиг	11,481.72	2.00	22,963.44
00001323	Био Хагалгааны багаж	11,820.01	5.00	59,100.05
00001326	Био Хагалгааны сав	6,069.20	5.00	30,346.00
00001321	Био Хархны тор	37,808.10	2.00	75,616.20
00001322	Био Хулганы тор	34,425.27	2.00	68,850.54
00001327	Био Чихний үзүүлэн	11,481.72	2.00	22,963.44
00001335	Био Элэг	11,481.72	2.00	22,963.44
00001312	Био шавьж хорхой	13,511.42	2.00	27,022.84
00001533	Бт вандан сандал	36,100.00	10.00	361,000.00
00001528	Бт водейболын иж бүрдэл	570,000.00	1.00	570,000.00
00001530	Бт матрас H207 загвар	47,500.00	10.00	475,000.00
00001531	Бт модон морь А-24 загвар	237,500.00	1.00	237,500.00
00001527	Бт сагсны самбар	1,092,500.00	1.00	1,092,500.00
00001532	Бт түлхэлтийн вандан А-38	142,500.00	1.00	142,500.00
00001529	Бт тениссенши ширээ иж бүрдэл	332,500.00	1.00	332,500.00
00001619	ДУ морин хур	150,000.00	5.00	750,000.00
00001258	Фи ёсгогч	109,364.90	1.00	109,364.90
00001245	Фи Иштанкин циркуль	16,874.35	4.00	67,497.40
00001308	Фи ажлын ширээ	573,867.26	2.00	1,147,734.52
00001269	Фи ампер метр	19,580.62	2.00	39,161.24
00001346	Фи ачаанууд	12,158.29	4.00	48,633.16
00001346	Фи ачаанууд	22,963.45	2.00	45,926.90
00001293	Фи багаж хэрэгсэл	34,425.27	2.00	68,850.54
00001295	Фи вакусын насос	57,388.72	2.00	114,777.44
00001270	Фи галавно метр	8,476.97	4.00	33,907.88
00001272	Фи дамжуулагч ба хөндийрүүлэгч	8,098.89	2.00	16,197.78
00001290	Фи динамо метр	4,059.40	8.00	32,475.20
00001309	Фи долгионы аппарат	88,550.55	1.00	88,550.55
00001251	Фи дулаан тэлэлтийн аппарат	4,535.16	2.00	9,070.32
00001254	Фи дулаан тэлэлтийн багаж	5,730.91	2.00	11,461.82
00001253	Фи дулааны аппарат	6,885.05	2.00	13,770.10
00001310	Фи дуу чимээ хэмжигч	330,323.40	1.00	330,323.40
00001307	Фи дууны долгион	10,128.59	4.00	40,514.36
00001279	Фи жин	103,295.71	2.00	206,591.42
00001277	Фи жолий клори метр	9,452.03	3.00	28,356.09
00001267	Фи индукцийн хэрэгсэл	14,187.99	2.00	28,375.98

00001306	Фи камиртоны набор	14,187.99	4.00	56,751.96
00001297	Фи конверцын үзүүлэн	14,844.65	2.00	29,689.30
00001280	Фи куб	16,874.35	5.00	84,371.75
00001265	Фи луужин	537.27	13.00	6,984.51
00001286	Фи манометр	8,098.89	1.00	8,098.89
00001285	Фи металлийн цуглуулга	20,933.75	1.00	20,933.75
00001288	Фи металлийн цуглуулга 1 см	4,855.36	1.00	4,855.36
00001289	Фи металлийн цуглуулга 2 см	14,267.58	1.00	14,267.58
00001291	Фи метр	2,559.74	10.00	25,597.40
00001300	Фи налуу хавтгай	14,187.99	4.00	56,751.96
00001301	Фи налуу хавтгайн тэргэнцэр	4,059.40	4.00	16,237.60
00001248	Фи нарны зайд	29,410.72	1.00	29,410.72
00001284	Фи пүржин хэмжүүр	1,691.42	10.00	16,914.20
00001264	Фи попеншиметр	30,385.77	2.00	60,771.54
00001311	Фи радио долгионы хэмжигч	438,852.55	1.00	438,852.55
00001345	Фи резисторууд	2,706.26	4.00	10,825.04
00001304	Фи резонатын аппарат	34,425.27	1.00	34,425.27
00001292	Фи самбарын хэрэгсэл	42,544.06	1.00	42,544.06
00001252	Фи слайдууд 1/9	43,877.30	3.00	131,631.90
00001246	Фи соронзон 75 мм	1,691.42	4.00	6,765.68
00001246	Фи соронзон 75 мм	6,288.08	4.00	25,152.32
00001246	Фи соронзон 75 мм	7,283.03	4.00	29,132.12
00001247	Фи соронzon орны үзүүлэн	98,500.05	2.00	197,000.10
00001262	Фи спектроскоп	34,425.27	3.00	103,275.81
00001250	Фи суналт агшилтын аппарат	2,905.25	2.00	5,810.50
00001263	Фи тольны сав	27,002.94	3.00	81,008.82
00001261	Фи тольны цуглуулга	12,834.86	6.00	77,009.16
00001249	Фи тольны цуглуулга	45,906.99	3.00	137,720.97
00001257	Фи тооны машин	38,484.67	4.00	153,938.68
00001287	Фи туршилтын сав	2,228.69	5.00	11,143.45
00001302	Фи тэргэг	7,422.33	4.00	29,689.32
00001271	Фи уистонгигүүр	36,454.97	2.00	72,909.94
00001266	Фи хавчаар 1/200	45,694.72	1.00	45,694.72
00001296	Фи харилцах сав	1,353.13	2.00	2,706.26
00001305	Фи хонх	2,845.56	4.00	11,382.24
00001275	Фи хэлхээний диталууд	108,031.67	3.00	324,095.01
00001303	Фи хэмжигч таваг	1,014.85	4.00	4,059.40
00001256	Фи цаг хэмжигч	216,043.44	1.00	216,043.44
00001353	Фи цаг цаас хэмжигч	28,694.36	2.00	57,388.72
00001274	Фи цахилгаан ороомог	3,382.83	4.00	13,531.32
00001351	Фи цахилгаан соронзон	6,745.76	4.00	26,983.04
00001283	Фи цахилгаанмотор генератор	45,906.99	2.00	91,813.98
00001281	Фи чөлөөт уналтын аппарат	34,425.27	1.00	34,425.27
00001298	Фи чийдэн 1/10	1,353.13	4.00	5,412.52
00001294	Фи чийдэнгийн суурь	1,353.13	12.00	16,237.56
00001259	Фи шингэн хэмжигч 1/5	41,230.73	5.00	206,153.65
00001282	Фи электрескоп	14,187.95	4.00	56,751.80

00001276	Фи электро статик	10,805.16	2.00	21,610.32
00001273	Фи эпетргиз электрод 1/2	3,721.11	8.00	29,768.88
00001278	Фи эргэвч 1/10	27,679.51	1.00	27,679.51
00001278	Фи эргэвч 1/10	43,200.73	1.00	43,200.73
00001278	Фи эргэвч 1/10	45,906.99	1.00	45,906.99
00001260	Фи эргэвчи??д 1/10	18,227.48	1.00	18,227.48
00001260	Фи эргэвчи??д 1/10	57,110.13	1.00	57,110.13
00001209	Хө байшинтай хөрөө	2,713.50	20.00	54,270.00
00001212	Хө модог шкаф	6,601.64	1.00	6,601.64
00001204	Хө мужааны ширээ	27,135.00	10.00	271,350.00
00001214	Хө оёллын машин	26,890.79	3.00	80,672.37
00001208	Хө суурин ором	52,569.54	1.00	52,569.54
00001203	Хө төмөр ширээ	36,180.00	12.00	434,160.00
00001211	Хө төмөр шкаф	27,135.00	1.00	27,135.00
00001206	Хө точилын машин	189,946.40	1.00	189,946.40
00000740	Хүндэтгэлийн танхим	500,000.00	1.00	500,000.00
00001114	ХИ фельтр тогтоогч	2,288.39	14.00	32,037.46
00001115	ХИ хутгач	477.58	5.00	2,387.90
00001115	ХИ хутгач	16,794.76	1.00	16,794.76
00001116	ХИбөглоо 25мм	11,481.72	1.00	11,481.72
00001136	Хи хуруу шил	9,452.03	1.00	9,452.03
00001182	Хи Ca Ce2 2x500гр	4,735.96	1.00	4,735.96
00001190	Хи Cu 500гр	9,113.74	1.00	9,113.74
00001183	Хи Cu So4 2x500гр	9,113.74	1.00	9,113.74
00001185	Хи J2	19,580.62	1.00	19,580.62
00001175	Хи Je Ce3 500гр	4,397.68	1.00	4,397.68
00001189	Хи K MnO4 500гр	6,747.57	1.00	6,747.57
00001201	Хи K4Je/CN/6	21,610.31	1.00	21,610.31
00001184	Хи KJ 500гр	85,068.23	1.00	85,068.23
00001169	Хи KNO3 500гр	3,044.55	1.00	3,044.55
00001181	Хи Ka J/SO4/2 500гр	2,029.70	1.00	2,029.70
00001188	Хи Mg 4x25гр	10,267.88	1.00	10,267.88
00001171	Хи NH 4 Ce 500гр	3,641.52	1.00	3,641.52
00001176	Хи Na HCO3 500гр	1,830.71	1.00	1,830.71
00001174	Хи Na OH 500гр	4,059.40	1.00	4,059.40
00001187	Хи Na2 SO4 500гр	1,830.71	1.00	1,830.71
00001186	Хи PB /NO3/2 500ГР	6,288.08	1.00	6,288.08
00001202	Хи Snlphur Powder 500	2,089.84	1.00	2,089.84
00001166	Хи үелэх систем	11,481.72	1.00	11,481.72
00001167	Хи K Ce 500гр	1,989.90	1.00	1,989.90
00001168	Хи K2 Cr2 OZ 500гр	8,457.08	1.00	8,457.08
00001170	Хи H3 BO3 500гр	6,626.37	1.00	6,626.37
00001197	Хи атомын загвар	8,098.89	2.00	16,197.78
00001119	Хи бөглөө 16 мм	34,425.27	1.00	34,425.27
00001160	Хи бөглөө цюологч	3,641.52	1.00	3,641.52
00001163	Хи бөглөөтэй шилэн сав	13,173.14	1.00	13,173.14
00001145	Хи вакум үүсгэгч сав	131,731.38	1.00	131,731.38

00001135	Хи дусаагүр	2,845.56	5.00	14,227.80
00001135	Хи дусаагүр	28,356.08	1.00	28,356.08
00001149	Хи дусаагүр 10 мл	616.87	5.00	3,084.35
00001147	Хи дусаагүр 1 мл	477.58	5.00	2,387.90
00001128	Хи дусаагүр сав 60мл	676.57	12.00	8,118.84
00001178	Хи дусаагч сав 60 мл	3,044.55	6.00	18,267.30
00001125	Хи жин 2650/1гр	106,340.26	2.00	212,680.52
00001126	Хи конус колбо 250 мм	6,487.07	12.00	77,844.84
00001148	Хи лакумсын цаас 1/100	4,059.40	6.00	24,356.40
00001172	Хи микропремсарат	3,466.04	1.00	3,466.04
00001195	Хи микроскоп	1,063.69	15.00	15,955.35
00001137	Хи нарийн амтай пластмал сав	875.56	6.00	5,253.36
00001155	Хи плаамтмал юулүүр	1,154.14	4.00	4,616.56
00001133	Хи пластмал цилиндр 100 мл	616.87	6.00	3,701.22
00001133	Хи пластмал цилиндр 100 мл	676.57	10.00	6,765.70
00001198	Хи пластмал цилиндр 1000 мл	1,830.71	5.00	9,153.55
00001159	Хи пластмал цилиндр 120 мл	736.26	6.00	4,417.56
00001199	Хи пластмал цилиндр 250 мл	955.15	6.00	5,730.90
00001144	Хи пластмал цилиндр 500 мл	1,552.12	6.00	9,312.72
00001144	Хи пластмал цилиндр 500 мл	6,745.76	2.00	13,491.52
00001177	Хи спиртийн термоистр 1/40	8,775.46	1.00	8,775.46
00001200	Хи спиртний дэн	3,840.51	5.00	19,202.55
00001193	Хи сургалтын жин	1,566.59	17.00	26,632.03
00001162	Хи термометр	10,128.59	4.00	40,514.36
00001191	Хи термоском по ботаник	6,745.76	1.00	6,745.76
00001194	Хи тигелдийн хайч	636.77	12.00	7,641.24
00001140	Хи том амтай сав 250 мл	1,353.13	6.00	8,118.78
00001130	Хи тор	616.87	10.00	6,168.70
00001138	Хи угаагч сав 250мл	736.26	6.00	4,417.56
00001121	Хи уур шаазан 100мм	2,845.56	3.00	8,536.68
00001173	Хи ууршуулагч аяга	2,507.27	7.00	17,550.89
00001129	Хи ууршуулагч таваг	4,755.68	1.00	4,755.68
00001152	Хи фильтер тогтоогч	616.87	4.00	2,467.48
00001118	Хи фильтр цаас	1,830.71	5.00	9,153.55
00001165	Хи хөл 150мм	2,706.26	4.00	10,825.04
00001164	Хи хөл 200мм	3,044.55	4.00	12,178.20
00001179	Хи хавчаар 1/100	36,454.97	1.00	36,454.97
00001124	Хи хавчигч	2,288.39	5.00	11,441.95
00001142	Хи халбага	795.96	5.00	3,979.80
00001142	Хи халбага	1,830.71	2.00	3,661.42
00001131	Хи хий хураах шаазан	875.56	2.00	1,751.12
00001127	Хи хийн үүсгүүр	27,679.51	2.00	55,359.02
00001180	Хи химийн сав хатгах	47,260.13	1.00	47,260.13
00001141	Хи хуруу шил 16 мл 1/100	13,511.42	1.00	13,511.42
00001139	Хи хуруу шил 25 мл	9,452.03	1.00	9,452.03
00001161	Хи хуруу шилний тавиур	2,706.26	5.00	13,531.30

00001161	Хи хуруу шилний тавиур	3,382.83	5.00	16,914.15
00001153	Хи хуруу шилний угаалтуур	338.28	5.00	1,691.40
00001154	Хи хуруу шилний угаалтуур 16/25	616.87	5.00	3,084.35
00001122	Хи хуруу шилний хавчаар	397.98	5.00	1,989.90
00001192	Хи хуруун хавчаар	493.86	35.00	17,285.10
00001123	Хи хурай	1,691.42	1.00	1,691.42
00001134	Хи хэмжүүр тогтоогч	1,830.71	2.00	3,661.42
00001134	Хи хэмжүүр тогтоогч	18,904.05	2.00	37,808.10
00001157	Хи хэмжээтэй колба 250мл	6,487.07	2.00	12,974.14
00001143	Хи цилиндр 250 мл 1/3	106,340.26	2.00	212,680.52
00001158	Хи шилэн 1/60	4,596.67	3.00	13,790.01
00001146	Хи шилэн сав	2,964.95	2.00	5,929.90
00001146	Хи шилэн сав	7,422.33	2.00	14,844.66
00001117	Хи шилэн таваг	4,676.27	1.00	4,676.27
00001120	Хи шилэн таваг 120 мм	6,069.20	1.00	6,069.20
00001151	Хи шилэн таваг 75 мл 1/10	3,382.83	10.00	33,828.30
00001150	Хи шилэн уур	3,044.55	3.00	9,133.65
00001156	Хи штатив	12,834.86	10.00	128,348.60
00001196	Хи штатив хавчаар	4,059.40	10.00	40,594.00
00001132	Хи юүлүүр	1,412.83	2.00	2,825.66
	ДҮН			27,765,309.44



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СҮМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 06 сарын 02-рөдөр

Дугаар 23


Хажуу шинэ ус

Г Хөрөнгө бүртгэлд авах тухай Г

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 3 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журмын 2.3.1 дэхь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ :

1. 2013,2014 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн цаг уурын өртөөний барилгыг 58070.0 төгрөгөөр, гэрэлтүүлэг 28385.7, хүүхдийн тоглоомын талбайн хашаа 41000.0 төгрөгийн хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэн авахыг ЗДТГ-ын дарга Г. Эрдэнэцэцэгт үүрэг болгосугай.

2. Өмч хөрөнгийн эзэмшил ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдалд хяналт тавьж ажиллахыг ЗДТГ-ын дарга, нярав нарт даалгасугай.

ДАРГА  В.НЯМСҮРЭН



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СҮМҮН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 28

Хажуу шинэ ус

Г Орчны бүсийн сумын зөвлөл
байгуулах тухай Г

Монгол улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 2 дахь хэсгийн 3 дахь заалт, Байгаль орчны сайдын 1998 оны 112 дугаар тушаалаар батлагдсан Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн зөвлөлийг байгуулж ажиллах нийтлэг журмын 7,8 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ :

1. Их газрын чулууны Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн сумын зөвлөлийг доорхи бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

- Д. Түвшинбаатар /ИТХ-ын тэргүүлэгч/
- Б. Цэрэнмөнх /ИТХ-ын тэргүүлэгч/
- А. Цэцэгдэлгэр /Их газрын чулууны БЦГ-ын хамгаалалтын захиргааны мэргэжилтэн/
- Н. Гэрэлмаа /Их газрын чулууны БЦГ-ын хамгаалалтын захиргааны мэргэжилтэн/
- А. Чимэддорж /1-р багийн малчин/
- Д. Мөнх-Эрдэнэ /1-р багийн малчин/
- Д. Мөнхжаргал /1-р багийн малчин/

2. Орчны бүсийн зөвлөлийн ажиллах журам, “Эко бүс нутаг” хөтөлбөрийг үйл ажиллагаандaa мөрдөж ажиллахыг зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА
B. НЯМСҮРЭН



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 33

Хажуу шинэ ус

Газрын үнэлгээний бүсчлэл, төлбөрийн
хувь хэмжээг тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1.2 –ийн “д” заалт, Газрын төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3, 7 дугаар зүйл, Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоолыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ :

1. Говь-Угтаал сумын иргэд, аж ахуйн нэгж байгууллагад төрийн өмчийн газрыг эзэмшүүлж, ашиглуулсны төлбөрийн хувь хэмжээг 1-р хавсралтаар, сумын нутаг дэвсгэрийн газрын үнэлгээний бүсчлэлийн хил хязгаар, зургийг 2-р хавсралтаар баталсугай.

2. Тогтоосон хувь хэмжээний дагуу газрын төлбөрийг газар эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай байгуулах гэрээндээ тусган хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргад үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 10 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  В.НЯМСҮРЭН

Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн
2014.оны 09-р сарын 29-өдрийн
ЗЗ..тогтоолын Н.хавсралт

Говь-Угтаал сумын нутаг дэвсгэрийн үнэлгээний бүсчлэлийн газар эзэмших, ашиглах зориулалтын ангилал 1
нэгжид ногдуулах газрын төлбөрийн хувь, хэмжээ

1.Хот тосгон бусад суурины газар

№	Газар эзэмшил, ашиглалтын зориулалт		1-р бүс	2-р бүс
			Газрын төлбөрийн хэмжээ /төгрөг/ Сурь үнэ 8 сая төгрөг/0,1%-1,0%/	
1	Гэр бүлийн хэрэгцээний	Иргэн	8	7
2	Албан контор, барилга, байгууламжын доорх	ААНБ	8	8
3	Үйлдвэрлэл,	Иргэн	8	7
4	үйлчилгээний	ААНБ	8	7

2.Бусад

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	Газар эзэмшил, ашиглалтын зориулалт	Тооцох үзүүлэлтийн нэгж	Газрын төлбөрийн хэмжээ /төгрөг/	Үндэслэл
1.	Хедөө аж ахуйн	Өвөлжөө, хаваржааны доорх газар	1га	4000	МУ-ын Газрын төлбөрийн тухай хуулийн 7.3, ЗГ-ын 152-р тогтоол
2.		Бэлчээрийн газрын / Мал бүхий иргэдээс/	1 хонин толгой	57	МУ-ын Газрын төлбөрийн тухай хуулийн 6.2, ЗГ-ын 152-р тогтоол
3.		Уул уурхайн эдэлбэрт ашиглалт явуулж байгаа	1га	16000	МУ-ын Газрын төлбөрийн тухай хуулийн 7.4, ЗГ-ын 152-р тогтоол
4.		Тариалангийн зориулалтаар \Олон наст ургамал, мод бүт, жимс жимсгэнэ, төмс хүнсний ногоо тариалах \	1га	760	ЗГ-ын 152-р тогтоол
5.	Ойн сан болон усан сан бүхий газар	Ойн сан болон усан сан бүхий газар	1га	16000	МУ-ын Газрын төлбөрийн тухай хуулийн 7.5, ЗГ-ын 152-р тогтоол
6.	Тусгай хэрэгцээний газар	Тусгай хамгаалалттай газар нутагт зохих хууль тогтоомжын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа	1га	24000	МУ-ын Газрын төлбөрийн тухай хуулийн 7.6, ЗГ-ын 152-р тогтоол
7.		Аялал жуулчлалын үйл ажиллагаа	1га	8000	МУ-ын Газрын төлбөрийн тухай хуулийн 7.7, ЗГ-ын 152-р тогтоол
8.		Байгалийн үзэсгэлэнтэй газар болон тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх	1га	24000	МУ-ын Газрын төлбөрийн тухай хуулийн 7.7, ЗГ-ын 152-р тогтоол
9.	Зам шугам сүлжээний	Цахилгаан, дулаан, ус хангамж, ариутгах татуурга, зам тээвэр, холбоо, мэдээллийн зориулалтаар хот тосгон, бусад суурины гадна олгогдсон газар	1км	7500	МУ-ын Газрын төлбөрийн тухай хуулийн 7.4, ЗГ-ын 152-р тогтоол

Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн
2011 оны 09-р сарын 29-өдрийн
33..тогтоолын хавсралт

Говь-Угтаал сумын газрын төлбөрийн үнэлгээний бүсчилэлийн зураг

Говь-Угтаал сумын нутаг дэвсгэрт газрын төлбөрийн бүсийн хил хязгаар

№	Газрын төлбөрийн бүс	Бүсийн солбицол		Бүсийн талбайн хэмжээ/га/
		Үртраг	Өргөрөг	
1	1-р бүс	107° 29'30"89	46° 2'48"37	110 га
2	2-р бүс	107° 29'07"76	46° 3'00"82	304,5 га



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 35.

Хажуу шинэ ус

Цөлжилтөөс сэргийлэх зурvas газар
байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1.2 –ийн “з” заалт, Байгаль хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1-ийн 7, Засгийн газрын 2005 оны 44 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ :

1. Говь-Угтаал сумын 1 дүгээр багийн нутагт 40 га газрыг цөлжилтөөс сэргийлэх ногоон зурvas газар байгуулсугай.
2. Эко трассын шугамын дагуу ойжуулах ажлыг төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх, ногоон байгууламжийн талбайг тогтмол нэмэгдүүлсүгэй.
3. Ногоон хэрэм үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, төслийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч ё. Мөнх-Амгаланд үүрэг болгосугай.



